

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/070/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ

Утас: 99210906

Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn

Агуулга	
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.3 Нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5.1 Албан шаардлага	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
УЦУОШТ	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.09 № 16
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА Б.БУЛГАНБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Ус, цаг уурын орчны шинжилгээ хөтөлбөрийн хүрээнд үндсэн 3 арга хэмжээг хэрэгжүүлэх 2,624,364.5 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 97.6 хувь буюу 2,560,871.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 58,105.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 үндсэн зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Цаг уур, орчны шинжилгээний газраас 98.5 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,102,386,516.28</u>	<u>1,120,807,158.16</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	24,509,664.00	-
312	Банканд байгаа бэлэн мөнгө	24,509,664.00	-
3121	Төгрөг	24,509,664.00	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	24,509,664.00	-
33	АВЛАГА	-	21,954,264.00
335	Бусад авлага	-	21,954,264.00
3351	Байгууллагаас авах авлага	-	21,954,264.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,077,876,852.28	1,098,852,894.16
351	Түүхий эд материал	1,025,870,998.42	1,047,232,040.30
35110	Тусгай зориулалттай материал	1,025,870,998.42	1,047,232,040.30
354	Хангамжийн материал	52,005,853.86	51,620,853.86
35420	Аж ахуйн материал	757,910.00	757,910.00
35470	Бусад хангамжийн материал	51,247,943.86	50,862,943.86
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>880,405,348.46</u>	<u>821,300,755.29</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	880,405,348.46	821,300,755.29
392	Биет хөрөнгө	345,592,848.28	286,683,344.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	311,033,311.63	311,033,311.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	(188,523,478.15)	(193,626,883.69)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	72,567,573.78	72,267,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(69,754,195.30)	(72,267,573.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	319,549,740.00	305,385,360.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(105,641,036.92)	(142,685,402.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,077,900.00	7,995,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(716,966.76)	(1,418,941.20)
393	Биет бус хөрөнгө	534,812,500.18	534,617,410.96
39301	Программ хангамж	1,775,000.00	1,775,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(262,499.82)	(457,589.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	533,300,000.00	533,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,982,791,864.74</u>	<u>1,942,107,913.45</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>7,338,822.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	7,338,822.00
413	Өглөг	-	7,338,822.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,052,672.00
4136	Бусад өглөг	-	6,286,150.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	898,150.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	5,388,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,660,928,250.85</u>	<u>1,934,769,091.45</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,660,928,250.85	1,934,769,091.45

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	795,531,351.22	795,531,351.22
51101	Өмч: - төрийн	795,531,351.22	795,531,351.22
512	Хуримтлагдсан үр дүн	658,126,062.28	932,530,902.88
51210	Өмнөх үеийн үр дүн	658,126,062.28	980,553,676.17
51220	Тайлант үеийн үр дүн		(48,022,773.29)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	207,270,837.35	206,706,837.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,660,928,250.85	1,942,107,913.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,926,258,802.91	2,749,759,079.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	315,926,602.91	35,272,481.08
120	Нийтлэг татварын бус орлого	315,926,602.91	35,272,481.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	295,389,703.91	35,272,481.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	690,500.00	737,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	294,699,203.91	34,535,281.08
120009	Бусад орлого	20,536,899.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,610,332,200.00	2,714,486,598.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,542,221,700.00	2,616,634,598.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,542,221,700.00	2,616,634,598.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	68,110,500.00	97,852,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,520,000.00	97,852,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,590,500.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,604,395,189.02	2,797,736,852.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,604,395,189.02	2,797,736,852.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,522,546,518.60	2,586,996,772.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,044,867,629.97	2,196,294,244.64
210101	Үндсэн цалин	1,049,565,992.66	1,050,545,032.12
210102	Нэмэгдэл	624,582,737.31	842,528,851.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	256,150,000.00	156,996,700.00
210104	Урамшуулал	114,568,900.00	146,223,661.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	253,517,270.50	274,213,085.99
210201	Тэтгэврийн даатгал	172,919,946.41	186,149,781.50
210202	Тэтгэмжийн даатгал	20,261,820.23	21,904,977.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,268,300.00	11,778,873.74
210204	Ажилгүйдлийн даатгал	10,013,201.10	11,552,910.68
210205	Эрүүл мэндийн даатгал	40,054,002.76	42,826,542.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,688,721.11	23,413,842.36
210301	Гэрэл, цахилгаан	6,024,834.62	8,913,868.33
210302	Түлш, халаалт	16,125,268.65	12,297,769.82
210303	Цэвэр, бохир ус	1,838,617.84	1,549,704.21
210304	Байрны түрээс	700,000.00	652,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	62,075,028.00	11,311,918.00
210401	Бичиг хэрэг	1,666,600.00	1,384,750.00
210402	Тээвэр, шатахуун	6,355,000.00	3,400,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,516,182.00	4,761,268.00

Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,636,100.00	1,765,700.00
210408	Бараа материал акталсны зардал	46,841,146.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,363,519.98	10,888,039.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,376,819.98	10,888,039.20
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	99,000.00	-
210604	Урсгал засвар	2,887,700.00	-
2107	Томилолт, зочны зардал	4,244,200.00	1,469,400.00
210702	Дотоод албан томилолт	4,244,200.00	1,469,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,213,476.00	5,730,849.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,442,800.00	3,751,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	325,000.00	20,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	490,100.00	169,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,500.00	71,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,500.00	48,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	88,000.00	92,900.00
210807	Газрын төлбөр	1,754,576.00	1,576,849.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,576,673.04	63,675,393.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,388,700.00	1,944,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,360,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,827,973.04	61,730,793.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,848,670.42	210,740,080.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,281,450.00	152,723,817.20
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	45,281,450.00	6,088,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		146,635,817.20
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,567,220.42	58,016,262.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,567,220.42	58,016,262.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	321,863,613.89	(47,977,773.27)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	45,000.02
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		45,000.02
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(45,000.02)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	321,863,613.89	(48,022,773.29)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,631,559,599.00	2,715,223,798.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,227,399.00	737,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,227,399.00	737,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	690,500.00	737,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	690,500.00	737,200.00
120009	Бусад орлого	20,536,899.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,610,332,200.00	2,714,486,598.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,542,221,700.00	2,616,634,598.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,542,221,700.00	2,616,634,598.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	68,110,500.00	97,852,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,000,000.00	-

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,520,000.00	97,852,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,590,500.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,487,197,950.00	2,739,733,462.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,487,197,950.00	2,739,733,462.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,405,349,279.58	2,512,427,117.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,044,867,629.97	2,196,294,244.64
210101	Үндсэн цалин	1,049,565,992.66	1,050,545,032.12
210102	Нэмэгдэл	624,582,737.31	842,528,851.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	256,150,000.00	156,996,700.00
210104	Урамшуулал	114,568,900.00	146,223,661.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	253,517,270.50	274,213,085.99
210201	Тэтгэврийн даатгал	172,919,946.41	186,149,781.50
210202	Тэтгэмжийн даатгал	20,261,820.23	21,904,977.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,268,300.00	11,778,873.74
210204	Ажилгүйдлийн даатгал	10,013,201.10	11,552,910.68
210205	Эрүүл мэндийн даатгал	40,054,002.76	42,826,542.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,688,721.11	23,413,842.36
210301	Гэрэл, цахилгаан	6,024,834.62	8,913,868.33
210302	Түлш, халаалт	16,125,268.65	12,297,769.82
210303	Цэвэр, бохир ус	1,838,617.84	1,549,704.21
210304	Байрны түрээс	700,000.00	652,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,857,482.00	9,669,296.00
210401	Бичиг хэрэг	1,666,600.00	794,800.00
210402	Тээвэр, шатахуун	6,355,000.00	3,400,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,516,182.00	3,708,596.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, арнутгал	60,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,259,700.00	1,765,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,361,800.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,274,100.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	-
210604	Урсгал засвар	2,887,700.00	-
2107	Томилолт, зочны зардал	4,244,200.00	1,469,400.00
210702	Дотоод албан томилолт	4,244,200.00	1,469,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,063,476.00	5,422,649.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,292,800.00	3,526,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	490,100.00	169,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,500.00	71,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,500.00	48,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	88,000.00	92,900.00
210807	Газрын төлбөр	1,754,576.00	1,513,649.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,748,700.00	1,944,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,388,700.00	1,944,600.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,360,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,848,670.42	227,306,344.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,281,450.00	147,335,817.20
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	45,281,450.00	700,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	146,635,817.20
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,567,220.42	58,105,462.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,567,220.42	58,105,462.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	21,865,064.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	21,865,064.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	144,361,649.00	(24,509,664.00)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	134,974,900.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	134,974,900.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	134,974,900.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	134,974,900.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(134,974,900.00)	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9,386,749.00	(24,509,664.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,122,915.00	24,509,664.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,509,664.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	795,531,351.22	211,270,837.35	654,126,062.28	1,660,928,250.85
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,564,000.00	4,564,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	795,531,351.22	211,270,837.35	658,690,062.28	1,665,492,250.85
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(4,564,000.00)	-	(4,564,000.00)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	795,531,351.22	206,706,837.35	980,553,676.17	1,982,791,864.74
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	795,531,351.22	202,142,837.35	1,302,417,290.06	1,982,791,864.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	564,000.00	564,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	795,531,351.22	206,706,837.35	981,117,676.17	1,983,355,864.74
D08	Тайлант үеийн үр дүн			(48,022,773.29)	(48,022,773.29)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	795,531,351.22	206,142,837.35	933,094,902.88	1,934,769,091.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,624,364,598.00	2,617,371,798.00	6,992,800.00	99.73
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,624,364,598.00	2,617,371,798.00	6,992,800.00	99.73
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,472,340,500.00	2,412,630,517.99	59,709,982.01	97.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,472,340,500.00	2,412,630,517.99	59,709,982.01	97.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	2,161,161,900.00	2,108,742,130.63	52,419,769.37	97.57
210101	Үндсэн цалин	1,056,350,300.00	1,050,545,032.12	5,805,267.88	99.45
210101	Үндсэн цалин	1,056,350,300.00	1,050,545,032.12	5,805,267.88	99.45
210102	Нэмэгдэл цалин	788,337,800.00	754,976,736.99	33,361,063.01	95.77
210102	Нэмэгдэл	788,337,800.00	754,976,736.99	33,361,063.01	95.77
210103	Унаа хоолны нэмэгдэл	156,996,700.00	156,996,700.00	-	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	156,996,700.00	156,996,700.00	-	100
210104	Урамшуулал	159,477,100.00	146,223,661.52	13,253,438.48	91.69
210104	Урамшуулал	159,477,100.00	146,223,661.52	13,253,438.48	91.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	263,913,200.00	263,913,200.00	-	100
210201	Тэтгэврийн даатгал	179,268,000.00	179,268,000.00	-	100
210201	Тэтгэврийн даатгал	179,268,000.00	179,268,000.00	-	100
210202	Тэтгэмжийн даатгал	21,089,700.00	21,089,700.00	-	100
210202	Тэтгэмжийн даатгал	21,089,700.00	21,089,700.00	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,200,100.00	11,200,100.00	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,200,100.00	11,200,100.00	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	11,148,100.00	11,148,100.00	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	11,148,100.00	11,148,100.00	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	41,207,300.00	41,207,300.00	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	41,207,300.00	41,207,300.00	-	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,009,700.00	23,413,842.36	5,595,857.64	80.71
210301	Гэрэл, цахилгаан	9,450,000.00	8,913,868.33	536,131.67	94.33
210301	Гэрэл, цахилгаан	9,450,000.00	8,913,868.33	536,131.67	94.33
210302	Түлш, халаалт	16,658,500.00	12,297,769.82	4,360,730.18	73.82
210302	Түлш, халаалт	16,658,500.00	12,297,769.82	4,360,730.18	73.82
210303	Цэвэр, бохир ус	2,248,700.00	1,549,704.21	698,995.79	68.92
210303	Цэвэр, бохир ус	2,248,700.00	1,549,704.21	698,995.79	68.92
210304	Байрны түрээс	652,500.00	652,500.00	-	100
210304	Байрны түрээс	652,500.00	652,500.00	-	100
2104	Хангамж, бараа материалын зардал	10,965,200.00	9,669,296.00	1,295,904.00	88.18
210401	Бичиг хэрэг	829,800.00	794,800.00	35,000.00	95.78
210401	Бичиг хэрэг	829,800.00	794,800.00	35,000.00	95.78
210402	Тээвэр, шатахуун	3,400,200.00	3,400,200.00	-	100
210402	Тээвэр, шатахуун	3,400,200.00	3,400,200.00	-	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,969,500.00	3,708,596.00	1,260,904.00	74.63
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,969,500.00	3,708,596.00	1,260,904.00	74.63
210406	БҮТЭЗүйлс	1,765,700.00	1,765,700.00	-	100

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,765,700.00	1,765,700.00	-	100
2107	Томилолт, зочны зардал	1,469,400.00	1,469,400.00	-	100
210702	Дотоод албан томилолт	1,469,400.00	1,469,400.00	-	100
210702	Дотоод албан томилолт	1,469,400.00	1,469,400.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,821,100.00	5,422,649.00	398,451.00	93.16
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,526,200.00	3,526,200.00	-	100
210801	Бусад нийтлэг АҮТ хураамж	3,526,200.00	3,526,200.00	-	100
210803	Даатгалын үйлчилгээ	169,800.00	169,800.00	-	100
210803	Даатгалын үйлчилгээ	169,800.00	169,800.00	-	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,500.00	71,500.00	-	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,500.00	71,500.00	-	100
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	48,600.00	48,600.00	-	100
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	48,600.00	48,600.00	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	348,400.00	92,900.00	255,500.00	26.66
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	348,400.00	92,900.00	255,500.00	26.66
210807	Газрын төлбөр	1,656,600.00	1,513,649.00	142,951.00	91.37
210807	Газрын төлбөр	1,656,600.00	1,513,649.00	142,951.00	91.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	152,024,098.00	204,741,280.01	(52,717,182.01)	134.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	152,024,098.00	146,635,817.20	5,388,280.80	96.46
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,388,000.00	-	5,388,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,388,000.00	-	5,388,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	146,636,098.00	146,635,817.20	280.80	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	146,636,098.00	146,635,817.20	280.80	100
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	58,105,462.81	(58,105,462.81)	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	58,105,462.81	(58,105,462.81)	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	58,105,462.81	(58,105,462.81)	-
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,624,364,598.00	2,617,371,798.00	6,992,800.00	99.73
1200042	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	648,000.00	737,200.00	(89,200.00)	113.77

1200042_1	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	648,000.00	737,200.00	(89,200.00)	113.77
120005	Түрээсийн орлого	648,000.00	737,200.00	(89,200.00)	113.77
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,623,716,598.00	2,616,634,598.00	7,082,000.00	99.73
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,623,716,598.00	2,616,634,598.00	7,082,000.00	99.73
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,623,716,598.00	2,616,634,598.00	7,082,000.00	99.73

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	100,496,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	100,496,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,796,600.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	87,552,114.01
210102	Нэмэгдэл	87,552,114.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,299,885.99
210201	Тэтгэврийн даатгал	6,881,781.50
210202	Тэтгэмжийн даатгал	815,277.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	578,773.74
210204	Ажилгүйдлийн даатгал	404,810.68
210205	Эрүүл мэндийн даатгал	1,619,242.71
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,944,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,944,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	700,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	700,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,865,064.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	21,865,064.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	97,852,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	97,852,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,852,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,509,664.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Ус цаг уур орчны шинжилгээний тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант онд Архангай аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төв нь “Ус, цаг уур, байгаль орчны мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн гамшиг, орчны ноцтой бохирдлоос иргэд, төр захиргаа, аж ахуйн нэгж байгууллагуудыг сэрэмжлүүлэх” зорилго бүхий улсын төсвөөр санхүүждэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд дараах зорилтуудыг тавин ажилласан байна. Үүнд:

- ✓ Ус цаг уур, орчны төлөв байдлын өөрчлөлтийн мэдээ мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангаж, байгаль цаг агаарын болзошгүй аюул гамшиг, орчны ноцтой бохирдлоос сэрэмжлүүлэх
- ✓ “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгжүүдийг арга зүй, технологийн удирдлагаар хангаж, тэдний тасралтгүй хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хяналт шинжилгээнд ашиглаж буй хэмжих хэрэгсэл, багаж төхөөрөмжийн үзлэг үйлчилгээ, шалгалт тохируулгыг тогтмол хийж хэмжлийн нэгдмэл байдлыг хангах
- ✓ Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, салбарын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ, санхүү, хангамж аж ахуйн үйл ажиллагааг хангаж ажиллах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Архангай аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төв нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль -2025.07.09

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд УЦУОШТ-ийн даргын 2025.05.07-ны өдрийн дотоод хяналт зохион байгуулах удирдамжийн дагуу санхүү, өмчийн бүртгэл, ашиглалт болон үндсэн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж тайлагнасан тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/170 дугаар тушаалаар баталсан ЦУОШГ-ын харьяа төсөвт байгууллагуудад мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" байна. Энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Архангай аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төв нь 2024 оноос unіcuss санхүүгийн системийг ашиглаж байгаа бөгөөд 2025 оны санхүүгийн тайланг 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын маягтын дагуу өөрчлөлт шинэчлэлт хийгдээгүй өмнөх хувилбараар байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,684 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	4
Банканд байгаа мөнгө бэлэн авлага	24,509.6	-	(24,509.6)	-
Барaa материал	1,077,876.9	1,098,852.8	20,976.0	1.9
Үндсэн хөрөнгө	880,405.3	821,300.7	(59,104.6)	(6.7)
Нийт хөрөнгө	1,982,791.8	1,942,107.8	(40,684.0)	(2.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,982,791.8	1,934,769.0	(48,022.8)	(2.4)
Богино хугацаат өр төлбөр	-	7,338.8	7,338.8	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,982,791.8	1,942,107.8	(40,684.0)	(2.1)

Хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 24,509.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба тайланд онд ахмадын сангаас ахмад настны гарын бэлэг, эмчилгээний болон буяны ажилд зориулж 2,644.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 21,865.1 мянган төгрөгийг СЯ-аас татсан байна.

- Авлагын үлдэгдэл 21,954.3 мянган төгрөг байна.

Авлагын данс 21,954.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь ахмадын сангаас 21,865.1 мянга, үйл ажиллагааны давсан орлогын 89.2 мянган төгрөгийг тус тус СЯ-аас татсан тул байгууллагаас авах авлагаар тусгажээ.

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 1.9 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 1,077,876.9 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 12,961.8 мянга, Цаг уур, орчны шинжилгээний төвөөс үнэ төлбөргүй шилжүүлсэн тусгай зориулалтын бараа материал 31,864.1 мянга нийт 44,825.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 23,849.9 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 1,098,852.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үлдэгдлийн 95.3 хувь буюу 1,047,232.0 мянган төгрөгийн ус, цаг уур, орчны шинжилгээний тусгай зориулалтын материал эзэлж байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 6.7 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 880,405.3 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд Цаг уур, орчны шинжилгээний төвөөс үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,439.2 мянган төгрөгийг соронзон холигч 1ш, 1,232.0 мянган төгрөгийн химийн бодис хадгалах шүүгээ 1ш нийт 2,671.2 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж орлогод авч нэмэгджээ.

Тайлант хугацаанд ТӨБЗГ-ын 2025.12.24-ны өдрийн 858 дугаар тогтоолоор ирүүлсэн зөвшөөрлийн дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг акталж данснаас хассан 3 нэр төрлийн 16,217.6 мянга, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал 61,730.8 мянга, данснаас хасалтын зөрүү (16,172.6) мянга, үндсэн хөрөнгийн гарз 45.0 мянга нийт 61,775.8 мянган төгрөгөөр буурч, 821,300.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- ✓ Биет бус хөрөнгөд бүртгэлтэй 533,300.0 мянган төгрөгийн 29 газрыг газрын гэрчилгээ, кадастрын зураг, газар олгосон захирамж, газрыг үнэлсэн үнэлгээчний тайлангийн дүнгээр тулган шалгаж судалгаагаар гаргуулан авч нэгтгэв.
- Өр төлбөр 7,338.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар тус байгууллагын бүтэц, орон тоог 10 хувиар буюу 7 орон тоогоор бууруулсантай холбоотойгоор 1 албан хаагчид олгох тэтгэмж 5,388.0 мянга, 2025 оны 10 сараас хангамж бараа материалын зардлын санхүүжилт татагдсантай холбоотой шуудан холбоо, бичиг хэрэг, газрын төлбөрийн татварт 1,950.8 мянган төгрөгийн өр төлбөр үүсжээ. Өр төлбөр тус бүрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулав.
- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнг 40,684.0 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,018,951.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, Цаг уур, орчны шинжилгээний төвд хүргүүлжээ.

Төсвийн төслийн саналаас 260,267.5 мянган төгрөгөөр бууруулан зардлыг анх 2,758,684.1 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд батлагдсан төсөвт 1 удаа тодотгол хийгдсэн, төсвийн сар, улирлын хуваарьт 3 удаа өөрчлөлт орсон байна. 2025 оны 07 дугаар сарын тодотголоор 134,319.6 мянган төгрөгөөр бууруулж 2,624,364.5 мянган төгрөгөөр тодотгон баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр улсын төсвөөс 2,624,364.5 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 2,560,871.1 мянган төгрөг буюу 97.6 хувийг зарцуулж, үлдсэн 58,105.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Санхүүжилтээс цалин, шимтгэл 52,419.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,595.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Харин бичиг хэрэг 34.9 мянга, шуудан холбоо 1,260.8 мянга, мэдээлэл технологи 255.4 мянга, нийтлэг үйлчилгээний төлбөр 142.9 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж 5,388.0 мянга нийт 7,082.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсан төсвөөс дутуу орж ирсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	71408-Ус, цаг уурын орчны шинжилгээ	2,624,364.50	2,560,871.11	63,493.39	97.58

1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	2,468,814.30	2,410,709.11	58,105.19	97.65
1.2	80202-Холбооны суваг ашигласны хөлс	3,526.20	3,526.20	0.00	100.00
1.3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	152,024.00	146,635.80	5,388.20	96.46

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын 2025.01.20-ны өдрийн А/20 дугаар захирамжийн дагуу албан хаагчдын орон нутгийн нэмэгдэлд зориулж 97,852.0 мянган төгрөгийн төсөв хуваарилагдсан ба гүйцэтгэлээр 91,827.6 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 6,024.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн төвлөрүүлжээ.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Архангай аймгийн УЦУОШТ нь 2025 онд ус, цаг уурын орчны шинжилгээ хөтөлбөрийн хүрээнд 9 үндсэн зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Цаг уур, орчны шинжилгээний газраас 98.5 хувьтай үнэлжээ.

3.5.5. Худалдан авах ажиллагааны талаар

Тус байгууллагын 2025 оны төсөвт хөрөнгө оруулалтын зардал батлагдаагүй байна.

3.5.5. Ерөнхий чиглэлийн судалгааны талаар

- Тайлант жилд Монгол Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн дагуу аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/39 дугаар тушаалаар тус байгууллагын бүтэц, орон тоог 10 хувиар буюу 7 орон тоогоор бууруулан 63 орон тоотой баталсан байна.
- Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын 2025.01.14-ны өдрийн А/05 дугаар тушаалаар аймгийн төвийн албан хаагчид хоолны хөнгөлөлтийг 1 өдрийн 20.0 мянга, сумдын албан хаагчид 1 өдрийн 7.0 мянган төгрөгөөр тогтоосон 2025 онд 156,996.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 100 хувь зарцуулсанд ерөнхий чиглэлээр судалгаагаар гаргуулан авч нэгтгэв.
- Үндсэн үйл ажиллагааны зардлаас бараа үйлчилгээний бусад зардалд 1,944.6 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр ахмадын гарын бэлэгт 100 хувь зарцуулсанд ерөнхий чиглэлээр судалгаагаар гаргуулан авч нэгтгэв.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 3,526.2 мянган төгрөгийг аймгийн болон сумдын албан хаагчдын интернэтийн төлбөрт зарцуулсанд ерөнхий чиглэлээр судалгаагаар гаргуулан авч нэгтгэв.
- Тайлант онд сургалт, семинарын зардал гараагүй байна.
- УЦУОШТ-ийн нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын 2025.01.20-ны өдрийн А/20 дугаар захирамжийн дагуу албан хаагчдын орон нутгийн нэмэгдэлд зориулж 97,852.0 мянган төгрөгийн төсөв хуваарилагдсан ба гүйцэтгэлээр 91,827.6

мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 6,024.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэнд ерөнхий чиглэлийн судалгаагаар гаргуулан авч нэгтгэл хийлээ.

- Аймгийн УЦУОШТ нь тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулаагүй бөгөөд үүнтэй холбоотой зардал гаргаагүй байна.
- Программ хангамжийн бүртгэлд 1,775.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба санхүүгийн болон нярвын 2 программыг ерөнхий чиглэлийн судалгаагаар гаргуулан авч нэгтгэв.
- Тайлант онд төрд учирсан хохиролтой холбоотой асуудал байхгүй байна.
- Тайлант онд гадаад томилолтын зардал гараагүй байна.

Ерөнхий чиглэлийн судалгааг ажлын баримтад хавсаргав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн УЦУОШТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн УЦУОШТ нь 2025 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 18 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны тодотголоор батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 2,597,855.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу **38,967.8** мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын **70** хувиар буюу **27,277.5** мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Энэ хүрээнд МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар “Төрийн

хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ыг тус тус баталсны дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

Тус байгууллага нь үндсэн санхүүжилтээс цалин, шимтгэлийн зардал болон бусад зардлуудаас 58,105.4 мянга, нэмэлт санхүүжилтээс 6,024.4 мянга нийт 64,128.8 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Архангай аймгийн УЦУОШТ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 176 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан болон төлөвлөх шатны ажлыг fas.audit.mn системд 2025 оны 10 сарын 02-оос 2025 оны 12 дугаар сарын 05-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар залруулагдаагүй нийт 17,182.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 4,501.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 12,681.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлж албан шаардлагын биелэлтийг бүрэн хангуулан fas системээр үнэлсэн байна. Үүнд:

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	7,733.8	4	7,733.8	100
Нийт дүн	4	7,733.8	4	7,733.8	100

Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодогч, няравт 3,508.8 мянган төгрөгийн балансийн урамшуулал олгосон, шатахуун зарцуулалтыг нормын дагуу зарцуулаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, нислэгийн нэмэгдлийг төсвийн төсөлд тусгалгүйгээр олгосон зэрэг зөрчилд албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангасан ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 11/А0370216

Эрдэнэбулган сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 186,388.989 төгрөгийн 5 нэр төрлийн 16 ширхэг барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг актлах, данснаас хасах, үнийг шинэчлэн тогтоох, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "...эд хөрөнгийн үр дүнг шийдвэрлэх, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ...", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд "Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах" 31.3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Зөрчлийг таслан зогсоож, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлэх, актлах, үнийг шинэчлэн тогтоох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Архангай аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга Б.Булганбаатар, нягтлан бодогч Г.Гэрэлмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА
Г.ЦОГ-ЭРДЭНЭ

Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

									албан шаардлага		байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үлдэх өртөггүй хөрөнгийг актлах, үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй.	1				1							
Дүн	1				1							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
уцшошт	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
уцшошт	0	0	0	0	0	0	0	0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.